

# Бидний мөнх бус байдлын өмнөх амьдрал, мөнх бус байдал ба мөнхийн гэр бүлүүд

## Бидний мөнх бус байдлын өмнөх гэр бүл

“Гэр бүл Бурханаас томилогддог бөгөөд энэ амьдралд болон үүрд мөнхөд хамгийн чухал нэгж байдаг. Бид дэлхий дээр төрөхөөсөө өмнө нэгэн гэр бүлийн гишүүд байсан. Бид ‘тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь бөгөөд тэнгэрлэг шинж чанар, хувь тавилантай юм’ [‘Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,’ *Ensign*, эсвэл *Лиакона*, 2010 оны 11-р сар, 129]. Бурхан бол бидний Тэнгэрлэг Эцэг бөгөөд бид мөнх бус байдлын өмнөх амьдралд Түүний гэр бүлийн нэг хэсэг нь байж, Түүний дэргэд амьдарч байсан. Тэнд бид анхныхаа хичээлүүдийг заалган, мөнх бус амьдралд бэлтгэгдсэн билээ (С ба Г 138:56)” (*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* [2010], 1.1.1).



“Бид ертөнцийг бүтээсэн агуу Бурханыг шүтэн биширдэг. Тэр бол тэнгэр дэх бидний Эцэг билээ. Тэрээр хүссэн учраас бид бий болсон юм. Бид Түүний сүнсэн хүүхдүүд билээ. Бид мөнх бус байдлын өмнөх амьдралд Түүнтэй гэр бүлийн харилцаа холбоотой оршин байсан. Бид Түүнийг энэ амьдрал дахь өөрийн мөнх бус эцгийг мэддэгтэй адил ойр дотно мэддэг байсан” (Брүс Р.Макконки, *How to Worship*, Brigham Young University Speeches of the Year [1971 оны 7-р сарын 20], 2).

Ярилцах асуултууд:

- Гэр бүл нь хэрхэн бидний мөнх бус байдлын өмнөх амьдралын төвд байсан бэ?
- Бурхан таны Эцэг бөгөөд та мөнх бус байдлын өмнөх дэлхийд Түүний гэр бүлийн хайртай гишүүн байсан гэдгийг мэдэх нь танд хэрхэн туслах вэ?
- Та нар Тэнгэрлэг Эцэг эхтэйгээ ямар харилцаатай байсан гэж бодож байна вэ?

## Бидний мөнх бус гэр бүл

“Бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний дагуу гэр бүлд төрсөн юм. Бидэнд аз жаргал авчирч, хайраар дүүрэн орчинд зөв зарчмуудад суралцаж, мөнх амьдралд бэлтгэхэд туслахын тулд Тэрээр гэр бүлүүдийг бий болгосон билээ.

Тэнгэрлэг Эцэгтэй эргэж очиход бэлтгэхэд нь хүүхдүүддээ туслах чухал үүрэг хариуцлага эцэг эхчүүдэд байдаг. Эцэг эхчүүд Есүс Христийг дагаж, Түүний сайн мэдээгээр амьдрахыг хүүхдүүддээ зааснаар энэ үүргээ биелүүлдэг” (*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь*, 1.1.4).



“Бурхан бол гэр бүлийг зохион бүтээгч юм. Тэрбээр хамгийн агуу аз жаргал, амьдралын хамгийн сайхан мөч, хамгийн дээд баяр баясгалан нь хамтдаа ойр дотно байж эцэг эх, үр хүүхдийн хувьд бие биенээ гэсэн сэтгэлтэй байх үед ирдэг гэж үзсэн” (Гордон Б.Хинкли, “What God Hath Joined Together,” *Ensign*, 1991 оны 5-р сар, 74).

Ярилцах асуултууд:

- Гэр бүл ямар байдлаар бидний мөнх бус амьдралын төвд байдаг вэ?
- Бид дэлхий рүү эцэг эх, ах эгч дүү, удам угсаа, үр удамгүй, гэр бүлийн холбоогүй хувь хүн болон цор ганцаар илгээгдсэн бол дэлхий дээрх амьдрал юугаараа ялгаатай байх байсан бэ?
- Ямар туршлага танд мөнх бус гэр бүлийн үүрэг, ач холбогдлыг ойлгоход тусалсан бэ?

**Бидний мөнхийн гэр бүл**

“Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа ч гэр бүлийн холбоог мөнхжүүлдэг” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129).



“Хэдий хувь хүний аврал хувь хүний өөрийнх нь дуулгавартай байдал дээр үндэслэгддэг ч, бид бүгд гэр бүлийн нэн чухал, салшгүй нэгэн хэсэг гэдгийг мөн хамгийн дээд адислалуудыг зөвхөн мөнхийн гэр бүлийн хүрээнд хүртэх боломжтой гэдгийг ойлгох нь мөн адил чухал билээ. Гэр бүл Бурханы бүтээснээр үүргээ гүйцэтгэх үед уг гэр бүлийн доторх харилцаа холбоо нь мөнх бус байдлын хамгийн үнэт зүйл байх юм. Гэр бүлийн хайр, харилцаа холбоог мөнхөд үргэлжлүүлэх нь Эцэгийн төлөвлөгөө билээ. Гэр бүлийн нэг хэсэг байх нь мөнх бус байдалд зөв шударгаар эцсээ хүртэл тэвчин, мөнх оршихуйд хамтдаа амьдра-

хын тулд гэр бүлийнхээ гишүүн нэг бүрд санаа тавих, хайрлах, дэмжин туслах, хүчирхэгжүүлэх гэсэн том хариуцлагыг дагуулдаг. Зөвхөн өөрсдийгөө аврах нь хангалтгүй. Эцэг эх, ах эгч дүү нар гэр бүлээрээ аврагдах нь мөн адил чухал зүйл юм. Хэрэв бид гэртээ, Тэнгэрлэг Эцэг дээрээ ганцаараа буцаж очвол биднээс “Гэр бүлийн чинь бусад хүн хаана байна вэ?” гэж асууна. Ийм учраас бид гэр бүл үүрд мөнх хэмээн заадаг билээ. Хувь хүний мөнхийн шинж чанар гэр бүлийн мөнхийн шинж чанар болох юм” (Роберт Д.Хэйлс, “The Eternal Family,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 65).

Ярилцах асуултууд:

- Гэр бүл ямар байдлаар бидний мөнхийн хувь заяаны төвд байдаг вэ?
- Гэр бүлийн гишүүд нэг нэгнийгээ аврахын тулд ямар ямар зөв шударга үйлдлийг хийх ёстой вэ?
- Хэзээ гэр бүлийн тань гишүүн таныг эцсээ хүртэл тэвчихэд урамшуулан хүчирхэгжүүлсэн бэ?